ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ.Товч танилцуулга
Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь 2025 онд “Ёс зүй, сахилга, дэг журмыг хэвшүүлэх” зорилтыг дэвшүүлж, өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад сахилга, ёс зүйн зөрчил 97 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/451 дүгээр тушаалаар “Ёс зүйн дэд хороо” байгуулагдсан. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хуульд нийцүүлэн төлөвлөх үүднээс Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатартай 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр тус дэд хорооны дарга, хурандаа Г.Ариунболд, нарийн бичгийн дарга, хошууч Д.Нацагдорж нар уулзаж, зөвлөмж авсан. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын өгсөн үүргийн дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, анхаарах асуудал” сэдвийн хүрээнд 15 удаагийн, бусад сэдвийн хүрээнд 17 удаагийн сургалт, мэдээллийг зохион байгуулж, нийт албан хаагчдын 86 хувийг хамруулан ажилласан. Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хороо нь 2025 онд нийт 11 ажил, арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100 хувийн биелэлттэй ажилласан. Төрийн албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын цохолт хийгдэж, Ёс зүйн дэд хороо байгуулагдсан өдрөөс хойш анхны ёс зүйн зөрчлийн шинжтэй асуудал орж ирсэн. Ёс зүйн дэд хорооны дарга тус гомдлыг тус хорооны гишүүн, хошууч Э.Золжаргалд хуваарилж, хууль, журмын хүрээнд шаардлагатай нотлох баримт, тайлбар, тодруулга авч, дараагийн хуралдаанд танилцуулахыг үүрэг болгосон. Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн гомдлын дагуу тус хорооны гишүүн гомдол гаргагч, гомдолд холбогдогч нартай холбогдож, мэргэжлийн нэгжийн илтгэх хуудсанд дурдагдсан тайлбараас гадна нэмэлт тайлбар гаргах эсэх, Ёс зүйн дэд хорооны хуралдаанд биечлэн оролцох эсэх, гомдолд холбогдогчийг гаргасан үйлдлээ хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг нягтлан шалгасан. Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нар албан хаагчийн гомдлыг хэлэлцэхдээ “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн хуудсыг бөглөж, тус хорооны гишүүн, хошууч Э.Золжаргал ёс зүйн дэд хороонд цохогдож ирсэн албан хаагчийн гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд хянан шалгасан тухай, нотлох баримт, холбогдох баримтыг танилцуулж, хэлэлцүүлэн хамтын шийдвэр буюу “Дүгнэлт”-ийг гаргаж ажилласан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 1.2-т “Ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог хөгжүүлнэ.” гэж заасны дагуу Хүний нөөцийн хэлтэс, Төрийн албаны зөвлөлийн Төрийн тусгай хамгаалалтын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан шалгалтын комиссын бүрэлдэхүүн сонгон шалгаруулалтад биеэ авч явах байдлыг ажиглах, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн төлөвшил, хариуцлага, шударга байдал, хандлагыг тодорхойлох асуултыг ярилцлагын шалгалтад нэвтрүүлсэн. Шатлан дэвших шалгалтад сүүлийн 3 жилийн хугацаанд сахилга, ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзаж ажилласан. Мөн удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан албан хаагчийг ёс зүйтэй, ёс

зүйгүй эсэхийг тодорхойлох зорилготой Хүний нөөцийн хэлтсийн албан хаагчид Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны реформ-бидний шийдэл” эрдэм шинжилгээний бүтээл шалгаруулах уралдаанд “Удирдах ажилтны ёс зүйн манлайлал албан хаагчдад нөлөөлдөг эсэхийг судалсан нь” сэдвээр тэргүүн байр эзэлсэн. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 1.4-т “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ.” гэж заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын албан хаагчийн тангараг өргөх ёслолыг 2025 онд 3 удаа зохион байгуулж, нийт тангараг өргөсөн 28 албан хаагчдад Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга хэлэх үгэндээ ёс зүйг эрхэмлэн сахиж, өргөсөн тангарагтаа үнэнч байж, байгууллага хамт олондоо эерэг соёлыг түгээх ажилд манлайлан ажиллах үүрэг чиглэлийг өгч, амжилт хүссэн. 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Удирдлагын академийн Хүний нөөцийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор Т.Төмөрийг урьж, “Байгууллагын соёл ба ёс зүй” сэдвээр сургалт, мэдээллийг Гадаад харилцааны яамны зөвшилцөл танхимыг түшиглэн зохион байгуулсан. Тус сургалт, мэдээлэлд Төрийн тусгай хамгаалалтын газрын 200 албан хаагч хамрагдсан бөгөөд тус сургалтаар байгууллагын болон хувь хүний соёлын талаарх ойлголтын талаар харилцан ярилцаж, байгууллага, албан тушаалтны ажлын гүйцэтгэлд хувь хүний болоод байгууллагын соёл хэрхэн нөлөөлдөг, мөн зөв соёлыг хэрхэн бүрдүүлэх талаарх мэдлэг, мэдээлэл олгосон. Монгол Улсын Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич С.Нарангэрэлийг Их тэнгэр цогцолборт урьж, нэгж бүрийн төлөөлөл 128 албан хаагчдад “Хүмүүн байхын учир ёс суртахуунд нь оршвой” сэдвээр лекц зохион байгуулсан. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад 15-аас дээш жил ажиллах хугацаандаа сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаж байгаагүй албан хаагчдыг сурталчлан таниулж, тэдний ажлын арга барил, туршлагыг бусад албан хаагчдад түгээн сурталчлах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд “Би хариуцлагатай албан хаагч” арга хэмжээг хэрэгжүүлсэн. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хэмжээнд 15-аас дээш жил ажиллах хугацаандаа ямар нэгэн сахилга, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй 68 албан хаагчийг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Б/197 дугаар тушаалаар “Төрийн тусгай хамгаалалтын алба үүсгэн байгуулагдсаны 87 жилийн ойг тохиолдуулан нэр бүхий 68 албан хаагч”-ийг Төрийн тусгай хамгаалалтын газрын үйл ажиллагааны журмын дагуу баяр хүргэж, сайшааж, тэдгээр албан хаагчдыг байгууллагын нийт албан хаагчдын дунд алдаршуулсан. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1-т “Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлнэ.” гэж заасны дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, анхаарах асуудал”, “Ёс зүйн дэд хорооны эрх үүрэг”, “Төрийн тусгай хамгаалалтын газрын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны танилцуулга”, “Төрийн тусгай хамгаалалтын газрын албан хаагчийн харилцааны ёс зүй”, “Төрийн тусгай хамгаалалтын газрын албан хаагчийн харилцааны сэтгэл зүй” тус тус сэдвээр давхардсан тоогоор 32 удаагийн сургалт, мэдээллийг зохион байгуулж, нийт албан хаагчдын 86 хувийг хамруулан ажилласан. Байгууллагад шинээр төрийн тусгай албан тушаалд 2024 оны 4 дүгээр улирал, 2025 онд томилогдсон нийт 50 албан хаагчдад 2 удаагийн 8 кредит хичээлийг орсон. Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Хүний эрхийн үндэсний комисс болон Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт сургалтад 2025 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд тус газрын Захиргааны хэлтсийн дарга, хошууч Б.Анхболд, Хүний нөөцийн хэлтсийн дарга, хошууч Д.Нацагдорж нар, 11 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд Хяналт шинжилгээ, аюулгүй байдлын хэлтсийн дарга,

дэд хурандаа Э.Гансүх, 12 дугаар сарын 04-ний өдөр Дэд дарга (хамгаалалт хариуцсан), хурандаа Ц.Адилтулга нар тус тус хамрагдсан. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.2-т “Судалгаа шинжилгээний үр дүнд суурилсан ёс зүйн үнэлгээг чанаржуулна.” гэж заасны дагуу Засгийн газрын тогтоолоор Төрийн тусгай хамгаалалтад байгаа 20 байранд үйл ажиллагаа явуулдаг Төрийн байгууллагуудын нийт 702 албан хаагчдаас “Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”-г 2025 оны 6 дугаар сарын 05-ны өдрөөс 12-ны өдрийг хүртэл хугацаанд авч, дүнг нэгтгэн Төрийн тусгай хамгаалалтын газрын даргад танилцуулсан. Тус судалгааны дүнг нэгтгэхэд “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмж”, “Алба хаагчийн мэргэжлийн үйл ажиллагааны чанар, хүртээмж” сайн байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Цаашид Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлагын талаарх олон нийтийн санаа бодлыг тандах, судалгааг авч, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаандаа ашиглаж хэвших зорилготой ажиллаж байна.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн Б/45 дугаар тушаалаар “Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах” ёс зүйн хариуцлага ногдуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг Төрийн тусгай хамгаалалтын газрын “www.sspa.gov.mn” сайтын Хүний нөөц->Ёс зүйн дэд хороо цэсэд байршуулсан.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны анхдугаар хуралдаан тус оны 1 дүгээр сарын 24-ний өдөр 4 асуудлаар, ээлжит хуралдааныг 1 дүгээр сарын 31-ний өдөр 2 асуудлаар, 6 дугаар сарын 19-ний өдөр 4 асуудлаар, 12 дугаар сарын 17-ны өдөр 3 асуудлаар тус тус хэлэлцэж, шийдвэрлэсэн. Хурлын тэмдэглэлийг тус өдрийн 01, 02, 03, 04 дугаар өгч, албажуулсан. Мөн Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны даргаар “Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны хуралдааны дэг”, “Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн жишиг загвар”-ыг хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын Дөрөв. Дэд хорооны чиг үүргийн 4.1.4-д “жил бүр хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж, эсхүл албан хаагчид зөвлөмж хүргүүлэх” гэж заасан. Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8-д “Байгууллагад, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг Хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэстэй хамтран тодорхойлж, дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулах” гэж баталсан. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлын хүрээнд Хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэст хүсэлт гаргаж 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулсан. Тус

уулзалтаар 2022-2024 оны хооронд явуулсан албаны шалгалтын талаар Хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн ахлах ажилтан, ахмад Э.Доржсүрэн танилцуулга хийсэн. Төрийн тусгай хамгаалалтын газрын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийтлэг үүсдэг шалтгаан нөхцөл, түүнд хийсэн дүгнэлтийг үндэслэн 5 зөвлөмжийг гаргаж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалыг 2026 онд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлын хүрээнд Ёс зүйн хороонд хүсэлт гаргаж 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хамтарсан уулзалт, сургалт, мэдээлэл авах ажлыг зохион байгуулсан. Тус уулзалт, сургалт, мэдээллээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, анхаарах асуудал сэдвээр Ёс зүйн хорооны Захиргаа, эрх зүйн хэлтсийн гомдол, мэдээлэл хариуцсан референт Д.Мөнхбат, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, анхаарах асуудал сэдвээр тус хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мөнхжин нар сургалт, мэдээлэл хийж, ярилцлага өрнүүлсэн. Тус сургалт, уулзалтаар сахилгын зөрчил, ёс зүйн зөрчлийг хэрхэн ялгаж ойлгох, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуваарилах, шалгах явцад харьяаллыг сахилгын болон гэмт хэргийн, зөрчлийн шинж байдлаас хамаарч холбогдох нэгж, байгууллагад шилжүүлэхийг анхааруулсан. Ёс зүйн дэд хороо Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахдаа ямагт тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу хүнлэг, энэрэнгүй байх; үнэнч, шударга байх; хариуцлагатай байх; манлайлах; хамтач байх зарчмыг баримталж, хуваарилагдсан гомдол мэдээллийг шалгах, нотлох баримт, холбогдох бусад баримтад дүн шинжилгээ хийж, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллахыг зөвлөсөн. Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030”-ийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн жил бүр тусгаж, ёс зүйн дэд хороотой хамтран ажиллах, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төсвийг жил бүр байгууллагын төсөвт тусгуулах талаар эрх бүхий албан тушаалтанд танилцуулах, шийдвэрлүүлэх үүрэг чиглэл өгсөн. Тус сургалт, мэдээлэл, уулзалтаар Төрийн тусгай хамгаалалтын газрын ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг сургаж, чадавхжуулсан үр дүнтэй ажил, арга хэмжээ болсон. Төрийн тусгай хамгаалалтын газрын Ёс зүйн дэд хорооны даргын баталсан Төрийн тусгай хамгаалалтын газрын хээрийн гаралт 2025-1 арга хэмжээний үеэр албан хаагчдад ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу гишүүд хуваарийн дагуу 2 сэдвийн хүрээнд 6 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг Төрийн тусгай хамгаалалтын газрын 2025 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 03/557 дугаар албан бичгээр Ёс зүйн хорооны даргад хүргүүлж ажилласан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө, үйл ажиллагааны явцад хагас жилийн байдлаар 2025 оны 6 дугаар сарын 19-ний

өдөр, жилийн эцсийн байдлаар 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцэж ажилласан.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, сургалт, ярилцлага, арга хэмжээг үе шаттай тогтмол зохион байгуулсан нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад сахилга, ёс зүйн зөрчил 97 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан.	Хууль, журамд заасны дагуу нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан ёс зүйтэй албан хаагч нь гишүүнээр томилогддог. Тус гишүүд гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх туршлагагүй тул мэдээ баримт дутуу бүрдүүлэх, хамтын шийдвэр гаргахад хүндрэл бэрхшээл үүсэх нөхцөл байдал бий болох эрсдэлтэй гэж үзэж байна.
Санал:	
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн тусгай албан хаагчдыг аливаа ёс зүйн зөрчил дутагдалд өртөхөөс урьдчилан сэргийлж ажлын байрны болон зорилтот сургалт, ярилцлага, нөлөөллийн ажлыг зохион байгуулах нь үр дүнтэй тул ёс зүйн дэд хорооны аль нэг гишүүнийг ёс зүйн хорооноос зохион байгуулж буй сургагч багш бэлтгэх сургалтад хамруулах. Цаашид Ёс зүйн дэд хороонд гомдол мэдээллийг хянан шалгах туршлагатай мэргэжлийн нэгжийн төлөөллийг гишүүнээр ажиллуулах, бусад гишүүдийг тогтмол чадавхжуулах. Хууль тогтоомжийн хэрэгжилт болон ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг сайжруулах үүднээс тухайн жилд шинээр хийж хэрэгжүүлсэн инновацын шинжтэй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж, харилцан мэдээлэл солилцон ажиллах саналтай байна.	

Шалгах хэсэг:

"Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Л.АЛТАНГЭРЭЛ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ХОШУУЧ Б.АНХБОЛД

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ Д.НАЦАГДОРЖ

Огноо: 2025 оны 12 дугаар сарын 25

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906
9923111371

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0,5	
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0,5	
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0	
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0.5	0,5	
Хэсгийн оноо				4	3,5	
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1.	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0	
Хэсгийн оноо				3	2	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	
Хэсгийн оноо				3	3	
Үнэлгээний нийт оноо, хувь				10	8,5	85.

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН
ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА, ДЭД ХУРАНДАА
Г.АРИУНБОЛД

2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	1 дүгээр улиралд	Нарийн бичгийн дарга
2.	Ёс зүйн дэд хорооны хуралдааны дэгийг боловсруулж, батлуулах	1 дүгээр улиралд	Нарийн бичгийн дарга
3.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Нарийн бичгийн дарга, гишүүд
4.	Ёс зүйн хорооны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, өгсөн үүрэг, албан даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэх	Тухай бүр	Нарийн бичгийн дарга, гишүүд
5.	Байгууллагын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	1, 3 дугаар улиралд	Нарийн бичгийн дарга, гишүүд
6.	Байгууллагад шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх 8 цагийн сургалт зохион байгуулах	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
7.	Төрийн байгууллага, иргэн, төрийн жинхэнэ албан хаагч хоорондын гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Гишүүд
8.	Байгууллагад, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг Хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэстэй хамтран тодорхойлж, дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулах	4 дүгээр улиралд	Гишүүд

9.	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг дарга, гишүүдэд хагас жил болон жилийн эцсийн байдлаар танилцуулж, үйл ажиллагааны явцад хяналт тавих	2, 4 дүгээр улиралд	Нарийн бичгийн дарга
10.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдын талаарх хагас, бүтэн жилийн мэдээ, тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	2, 4 дүгээр улиралд	Нарийн бичгийн дарга
11.	Ёс зүйн дэд хорооны тайлан, баримт бичгийг стандартын дагуу архивд хүлээлгэн өгөх	4 дүгээр улиралд	Нарийн бичгийн дарга

ТӨЛӨВЛӨСӨН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
АХМАД Д.НАЦАГДОРЖ